

## АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

**I. ТӨСӨВ:** Аймгийн төсвийн орлогод 5.8 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө нь 11.2 хувиар давж биелсэн байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.7 тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Сумдын төсвийн орлогын төлөвлөгөө 5.0 хувиар тасарсан байна. Үүнд Дарьганга, Мөнххаан, Баруун-Урт сумд төлөвлөгөөгөө 6.2-27.1 хувиар тасарсан байна.

Орон нутгийн төсвийн зарлага 5.2 тэрбум төгрөг болжээ.

Аймгийн дүнгээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 1.6 тэрбум төгрөг болсны дотор 0.4 тэрбум төгрөг нь төрийн удирдлага, 1.0 тэрбум төгрөг нь нийгэм бие хүнд үзүүлэх үйлчилгээ, 0.1 тэрбум төгрөг нь боловсролын салбарт тус тус хийгджээ.

**II. МӨНГӨ, ЗЭЭЛ:** Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 17.6 тэрбум төгрөгт хүрсэн нь 2009 оны жилийн эцсээс 4.6 тэрбум төгрөгөөр буюу 35.5 хувиар өсчээ.

Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 10.4 тэрбум төгрөг болж, 2009 оны жилийн эцсээс 3.0 тэрбум төгрөгөөр буюу 41.2 хувиар өссөний дотор бүх сумдад энэ үзүүлэлт нэмэгдсэн байна.

**III. ХӨДӨӨ АЖ АХУЙ:** Мал аж ахуй: Оны эхний төллөх эх малын 85.9 хувь болох 664.8 мянган эх мал төллөж, гарсан төлийн 96.9 хувь болох 648.9 мянган төл бойжиж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс төллөх эх мал 100.6, бойжиж буй төл 74.1 мянгаар тус тус дээгүүр байна.

Оны эхний малын 2.3 хувь болох 40.5 мянган том мал зүй бусаар хорогдсон нь урьд оны мөн үеэс 2.8 дахин олон байна.

Түмэнцогт суманд оны эхний малын 10.6 хувь нь болох 6.4 мянган мал зүй бусаар хорогдоод байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болсон байна. Сүхбаатар, Эрдэнэцагаан, Түмэнцогт сумд МИДаатгалд хамрагдсан малчид нөхөн төлбөр авах босго давж, 44 өрх нөхөн төлбөр авсан байна.

**Ургац хураалт:** Үр тариа 80 га-д, төмс 58.8 га-д, хүнсний ногоо 27.2 га-д, тэжээлийн ургамал 94.4 га-д тариалалт хийж, төмс 273.1 тн, хүнсний ногоо 131.2 тн, тэжээлийн ургамал 8.95 тн-ыг тус тус хураан аваад байна. Өнгөрсөн оны мөн үед үр тариа 25.0 тн, тэжээлийн ургамал 17.6 тн, төмс 310.2 тн, хүнсний ногоо 143.7 тн тус тус хураан авсан. Энэ оны хураан авалт өнгөрсөн оноос доогуур явцтай байна.

Байгалийн хадлан 9902.0 тн, гар тэжээл 430.0 тн тус тус бэлтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс байгалийн хадлан дээгүүр, гар тэжээл доогуур явцтай байна.

**IV. АЖ ҮЙЛДВЭР:** Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 20.3 тэрбум төгрөг болсон нь урьд оны мөн үеийнхээс 3.3 тэрбум төгрөг буюу 13.9 хувиар доогуур байна. Цайрын баяжмал 2009 оны эдийн засгийн хямралаас болж борлуулалт буурч, бүтээгдэхүүний тоо хэмжээ өссөн нь энэ оны бүтээгдэхүүний үйлдвэрлэлт буурхад нөөллөсөн байна. Гэхдээ боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт 69.5 хувиар нэмэгдсэн. Үүнд хэрэгжиж буй төслийн хүрээнд талх, нарийн боов, блок, замын хавтангийн үйлдвэрлэлт өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулалт 78.2 тэрбум төгрөгт хүрч, урьд оны мөн үеийнхээс 25.9 сая төгрөгөөр буюу 49.7 хувиар дээгүүр гүйцэтгэлтэй байгаагийн дотор уул уурхай, олборлох аж үйлдвэр, боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт 51.0-149.4 хувиар өссөн байна. Үүнд урьд онуудад үйлдвэрлэгдээд борлуулалт хийгдээгүй тоосгоны борлуулалт энэ онд хийгдсэн нь боловсруулах аж үйлдвэрийн борлуулалтын орлогыг өсгөж байна.

Гол нэр төрлөөс талх, нарийн боов, ул боов, хиам, нүүрс, дулаан, блок, замын хавтан, эсгий үйлдвэрлэлт мөн үеэс 6.5-220 хувиар нэмэгдсэн байна.

**V. БАРИЛГА, ТЭЭВЭР, ХОЛБОО:** Барилга: 3.3 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдээд байгаа нь урьд оны мөн үеэс 7.8 дахин өссөн байна.

**Тээвэр:** Тээвэр бүхий байгууллагууд 32.5 сая.тн км-ийн ачаа эргэлт, 6.7 сая.хүн км-ийн зорчигч эргэлт гүйцэтгэн, 3.9 тэрбум төгрөгийн орлоготой ажиллаж, өнгөрсөн оны мөн үеэс тээврийн салбарын үндсэн үзүүлэлтүүд давж биелсэн байна.

**Холбоо:** Холбоо ашиглалтын орлого 220.6 сая төгрөг, үүнээс хүн амын орлого 99.0 сая төгрөг орсон нь урьд оны мөн үеэс нийт орлого 29.1 сая төгрөг, хүн амын орлого 7.1 сая төгрөгөөр доогуур гүйцэтгэлтэй байна. Телефон цэгийн тоо 955 болж урьд оны мөн үеэс 46.5 хувиар буурсан байна

**VI. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС:** Хэрэглээний үнийн индекс 9-р сард 2009 оны жилийн эцсийнхээс 6.0 хувиар, өмнөх сарыхаас 4.3 хувиар тус тус өслөө. Энэ нь Хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 1.1-9.7 хувиар өссөн гол нөлөө үзүүлсэн байна.

**VII. СОЁЛ, БОЛОВСРОЛ:** **Соёл:** Мэргэжлийн урлагийн байгууллага 55 удаагийн тоглолтоор 16.1 мянган хүнд үйлчилж, 12.4 сая төгрөгийн орлоготой ажилласан нь урьд оноос 454 мянган төгрөгөөр дээгүүр байна.

Музейн нийт үзмэр 1765-д, үзэгчид 0.9 мянгад хүрч, 570.1 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь урьд оноос дээгүүр байна.

Нийтийн номын сангийн номын фонд 41.6 мянгад хүрч, 16.6 мянган уншигчидтай болсноор 726.7 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь урьд оноос 4.1 дахин өссөн байна.

**Боловсрол:** 2010-2011 оны хичээлийн жилд нийт 15 ерөнхий боловсролын сургуульд 519 үндсэн багш багшилж, 367 бүлэгт 10.4 мянган сурагчид суралцаж байна. Үүнээс 1-5-р ангид 5.5 мянга, 6-9-р ангид 3.7 мянга, 10-11-р ангид 1.2 мянган сурагчид суралцаж, 1-р ангид 1.0 мянган сурагч элссэн байна. 11-р ангид 0.5 мянган сурагч суралцаж байна. Аймгийн хэмжээнд нэг багшид дундажаар 20 хүүхэд ноогдож байна. 1.2 мянган сурагч дотуур байранд сууж байна.

**VIII. ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ:** Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 2.9 тэрбум төгрөг болж төлөвлөгөө 3.6 хувиар давж биелэв. Харин сайн дурын даатгалын шимтгэлийн орлогоор 60.4 сая төгрөг орж, төлөвлөгөө нь 53.1 хувиар тасарсан байна.

6171 өндөр настанд 4.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгожээ. Нийгмийн халамжийн сангаас 0.8 тэрбум, улсын төсвөөс 0.5 тэрбум төгрөгийг тус тус иргэдэд олгосон байна. 2010 оноос эхлэн хүний хөгжил сангаас иргэн бүрт 70.0 мянган төгрөг олгож байгаа бөгөөд эхний 9-н сард 54.5 мянган хүнд 3.9 тэрбум төгрөг олгож байна.

**IX. ЭРҮҮЛ МЭНД:** 855 эх амаржиж, 863 хүүхэд амьд төрсөн байна. 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 20 болж урьд оны мөн үеэс 9-өөр олон, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 5 болж өнгөрсөн оны мөн үеэс 2-оор олон байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 384 болж, урьд оны мөн үеэс 213-аар доогуур байгаагийн дотор вирус гепатит, салхинцэцэг, тэмбүү, заг, трихоминиаз зэрэг өвчнүүд буурсан байна.

2009 онд гарч байсан гар хөл амны өвчин энэ онд 3 тохиолдол бүртгэгдсэн байна.

**X. АЖИЛГҮЙЧҮҮД:** ХХҮХэлтэст бүртгэлтэй ажил идвэхитэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 1270 болж, урьд оны мөн үеийнхээс 48 хүнээр буурсан байна. Ажилгүйчүүдийн 71.0 хувь нь 16-34 насны залуучууд, 19.2 хувь нь дээд, 3.4 хувь нь тусгай дунд, 35.7 хувь нь бүрэн дунд, 7.9 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

2066 хүн шинээр бүртгүүлж, 1755 хүн ажилд орсны дотор 524 нь шинэ ажлын байр байна.

**XI. АЖИЛЛАГЧДЫН ДУНДАЖ ЦАЛИН, ОРЛОГО:** 2-р улирлын мэдээнд хамрагдсан 40 аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын дундаж цалин, орлогын судалгааг авч үзэхэд санхүү, цахилгаан эрчим хүч, шатдаг хий, ус дулаан, уул уурхай, олборлох аж үйлдвэр, төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын салбарууд өндөр үзүүлэлттэй байна.

**XII. ГЭМТ ХЭРЭГ:** 120 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 24-өөр доогуур байна.

Гэмт хэргийн улмаас 24 хүн гэмтэсэний зэрэгцээ 29 хүн нас барсан. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 98.2 сая төгрөгийн хохирол учирсны 89.0 саяыг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 105 хүн холбогдон сэжиглэгдсэний 19.0 хувь нь согтуугаар, 15.2 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 1910 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс 201 хүнээр доогуур байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 87 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

**XIII. ТӨСӨЛ:** **Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төсөлд** хамрагдахаар 2.1 тэрбум төгрөгийн 113 төслийг иргэд бичиж ирүүлснээс аймгийн дэд комисс болон банкны шалгуураар орж, 601.8 сая төгрөгийн 46 төсөл батлагдаж санхүүжилтээ аваад үйл ажиллагаагаа эхлээд байна.

**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас** 342 төсөлд 301.3 сая төгрөгийн зээл олгосны дотор Дарьганга 56 төсөлд 40.0 сая, Эрдэнэцагаан 42 төсөлд 38.8 сая, Сүхбаатар 36 төсөлд 25.2 сая төгрөгийн зээл авсан нь бусад сумдын зээл олголтоос дээгүүр үзүүлэлттэй байна.

**Тогтвортой амжиргаа-II төслийн** хүрээнд аймгийн хэмжээгээр 236.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний дотор тохижуулалтанд 76.7 сая, засварт 54.1 сая, шинээр 25.5 сая, эмнэлгийн тоног төхөөрөмжинд 10.3 сая төгрөгийг тус тус зарцуулжээ. Мөн аймгийн хэмжээгээр бэлчээрийн эрсдлийг бууруулахад зарцуулахаар 167.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Үүнээс шинээр худаг гаргахад 3.5 сая, өвс тэжээлийн агуулах барихад 21.7 сая, 10 га бэлчээр хамгаалахад 28.0 сая, 4 тн малын тэжээл бэлтгэхэд 12.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

**XIV. ГАЗАР ӨМЧЛӨЛ:** Аймгийн хэмжээгээр нийт 4908 иргэн газар өмчилж авахаар өргөдөл гаргаснаас 4638 иргэнд 449.24 га газар өмчлүүлэхээр Засаг даргын захирамжаар шийдвэрлэж олгосон байна.

**XV. ДААТГАЛ:** Даатгалын компаниуд 2582 иргэнийг 8 төрлийн даатгалд хамруулан 61.7 сая төгрөгийг даатгалын хураамжаар оруулсан байна. Эхний 9 сард 210 хүнд 13.6 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгожээ.

## **АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**